

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ, САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2011 оны 3 дугаар
сарын 18-ний өдөр

Дугаар 156 / 45

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 15 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд хяналт шалгалт хийх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн мэдээллийн алба (Б.Төмөрбат), Ажлын алба/Х.Бум-Эрдэнэ/ -т тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ

Л.ШҮРЭВДОРЖ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА

Д.БАЯССАЙХАН

Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах
хорооны даргын 2011 оны 3 дугаар сарын
18 өдрийн ... дугаар хамтарсан тушаалын хавсралт

**МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ
ЧИГЛЭЛЭЭР БАНКНААС БУСАД МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДЭД
ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, түүнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороо /цаашид Хороо гэх/-ны тогтоол, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан заавар, журмыг мэдээлэх үүрэгтэй этгээд хэрхэн хэрэгжүүлж байгаад зайнаас болон газар дээр нь хяналт шалгалт хийж дүгнэлт гаргах, зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авахад энэхүү журмыг баримтална.

1.2. Энэ журамд дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.2.1 “Мэдээлэх үүрэгтэй этгээд” /цаашид МэҮЭ гэх/ гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.5, 4.1.8-д зааснаас бусад этгээдийг.

1.2.2 “Хэрэгжилтэд хяналт тавих ажилтан” гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, түүнтэй холбогдуулан Хорооны тогтоол болон Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан журам, МэҮЭ-ийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дотоод хяналтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий тухайн МэҮЭ-ийн ажилтныг.

1.2.3 “Дотоод хяналтын хөтөлбөр” гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор гаргасан МэҮЭ-ийн дотоод журам болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр баримтлах бодлогыг тодорхойлсон баримт бичгийг.

1.2.4 Зайнаас тавих хяналт гэж МэҮЭ-ийн ирүүлсэн тайлан, мэдээ, судалгаа болон газар дээрх шалгалтын дүгнэлт, өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтэд үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид үүсч болзошгүй эрсдлийг тогтоох, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах зорилгоор байнгын хяналт тавихыг .

1.2.5 “Баримтын шалгалт” гэж хяналт шалгалт хийх чиглэлийн хүрээнд МэҮЭ-ийн холбогдох бүх үндсэн баримтад шалгалт хийхийг хэлнэ.

1.2.6 “Түүврийн арга” гэж цаг хугацаа болон чиглэлийн хувьд холбогдох материалыг нь сонгон авч шалгалт хийхийг хэлнэ. Жишээлбэл, цаг хугацааны хувьд тухайн МэҮЭ-ийн зөвхөн нэгдүгээр улирлын, 7 дугаар сарын гэх мэт. Чиглэлийн хувьд зөвхөн гадаад төлбөр тооцоо гэх мэт.

1.2.7 “Шинжилгээ, судалгааны арга” гэж тухайн МэҮЭ-ийн гаргаж өгсөн мэдээлэлд дүн шинжилгээ, судалгаа хийх, бусад төрийн байгууллага болон хамтын ажиллагааны гэрээ бүхий байгууллагуудын мэдээллийн сангаас мэдээлэл авч тулган шалгахыг.

1.2.8 “Асуулгын арга” гэж тусгайлан бэлтгэсэн асуулгын хуудсаар МэҮЭ-ийн ажилтнууд болон харилцагчдын саналыг авч, нэгтгэн дүгнэлт хийхийг.

1.2.9 “Эрсдлийн үнэлгээний арга” гэж МэҮЭ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, байршил, харилцагчийн байдал, хувь эзэмшигч, удирдлага болон ажилтнуудын эрсдлийн үнэлгээн дээр тулгуурлан хяналт шалгалт хийхийг.

ХОЁР. ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АРГА, ХЭЛБЭР

2.1 Газар дээрх хяналт шалгалт нь хуваарийн дагуу болон гэнэтийн шалгалт гэсэн 2 хэлбэртэй байна.

2.1.1 Хуваарийн дагуу хийгдэх шалгалтыг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан газар дээрх шалгалтын хуваарийн дагуу хийнэ. Шаардлагатай гэж үзвэл Монголбанкны СМА-ны хянан шалгагч шалгалтын хэсэгт орж ажиллаж болно.

2.1.2 Гэнэтийн шалгалтыг тодорхой мэдээллийн дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрээр СМА-ны хянан шалгагч хийнэ.

2.2 Газар дээрх хяналт шалгалтад баримтын шалгалт, түүврийн арга, шинжилгээ судалгааны арга, асуулгын арга, эрсдлийн үнэлгээний аргыг тус тус хэрэглэнэ.

ГУРАВ. ЗАЙНААС ТАВИХ ХЯНАЛТ

3.1 Зайнаас тавих хяналтыг СМА-ны хянан шалгагч гүйцэтгэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагч нар шаардлагатай мэдээллийг МэҮЭ-ээс гаргуулан авч СМА-нд ирүүлэх хэлбэрээр хамтран ажиллана.

3.2 Зайнаас хяналт тавихдаа МэҮЭ-эд холбогдолтой дараахь тайлан, мэдээллийг ашиглана:

3.2.1 Газар дээрх хяналт шалгалтын дүгнэлт, акт материал;

3.3.2 Өгөгдсөн үүрэг, даалгаврын биелэлтийн талаарх тайлан, мэдээлэл;

3.3.3 МэҮЭ-ийн ТУЗ, хувь нийлүүлэгч, хяналтын зөвлөл, удирдлагад гарсан өөрчлөлтийн талаар тухай бүр нь ирүүлсэн мэдээлэл;

3.3.4 Хэрэгжилтэд хяналт тавих ажилтны улирал тутам хийх ажлын төлөвлөгөө, хийсэн ажлын тайлан;

3.3.5 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдолтой МэҮЭ-ийн дотоод журам, бодлого болон хөтөлбөрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл;

3.3.6 Сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээний тайланд гарсан өөрчлөлт, мэдээллийн чанарын талаар СМА-ны шинжээч нарын гаргасан статистик судалгаа;

3.3.7 МэҮЭ-ийн хяналтын зөвлөл, дотоод хяналтын нэгжийн хийсэн шалгалтын дүгнэлт, тайлан;

3.3.8 Бусад мэдээлэл. /Шүүх, хууль хяналтын байгууллагаас МэҮЭ-тэй холбоотой гаргасан шийдвэр, олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр гарсан мэдээлэл, хөндлөнгийн аудитын дүгнэлт зэрэг /

3.4 Тайлан, мэдээллийг ирүүлээгүй эсхүл ирүүлсэн тайлан, мэдээлэл нь тавигдсан шаардлагыг хангаагүй бол СМА-ны хянан шалгагч нь шаардах, улсын байцаагчийн мэдэгдэл хүргүүлэх, захиргааны хариуцлага ногдуулах арга хэмжээг шат дараалуулан авна.

3.5 Улсын байцаагчийн мэдэгдлийг үл хэрэгсэх, зөрчил дутагдлыг арилгах талаар арга хэмжээ авахгүй байгаа МэҮЭ-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай санал боловсруулж Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлнэ.

ДӨРӨВ. ГАЗАР ДЭЭРХ ХЯНАН ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛ, ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ

4.1 Хянан шалгагч нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр МэҮЭ-ийн үйл ажиллагаанд хийх хуваарьт шалгалтын явцад дараахь дөрвөн чиглэлээр газар дээрх хяналт шалгалтыг хийнэ:

4.1.1 МэҮЭ-ийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтны эрх үүрэг, МэҮЭ-ийн бусад нэгж болон удирдлагатай харилцах ажил хэргийн уялдаа холбоо;

4.1.2 Харилцагчийг таньж, мэдэх талаар МэҮЭ-ийн үйл ажиллагаа;

4.1.3 Сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэхтэй холбоотой үйл ажиллагаа;

4.1.4 Бичиг баримтын хадгалалт, тусгайлан хянах гүйлгээ болон МУТС-ээс урьдчилан сэргийлэх бусад үйл ажиллагаа.

4.2 Энэ журмын 4.1-д заасны дагуу МэҮЭ-ийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөхдөө хэрэгжилтэд хяналт тавих ажилтны дараахь үзүүлэлтийг харгалзана:

1. Хэрэгжилтэд хяналт тавих ажилтны эрх үүрэг, МэҮЭ-ийн удирдлага, бусад нэгжтэй харилцах ажил хэргийн уялдаа холбоо:

4.2.1 Алба эсхүл ажилтныг албан ёсоор томилсон эсэх;

4.2.2 Ажилтны боловсрол, дадлага туршлага болон ёс суртахуун;

4.2.3 Гүйлгээг сэжигтэй гүйлгээ гэж тооцон холбогдох тайланг илгээх шийдвэрийг бие даан гаргах эрхтэй эсэх, энэ шийдвэрт МэҮЭ-ийн удирдлагын оролцоо байгаа эсэх;

4.2.4 Ажил үүргээ хариуцлагатай гүйцэтгэх нөхцөл бололцоогоор хангагдсан эсэх; /Ажлын байр, холбоо, харилцааны хэрэгсэл, компьютер, программ хангамж, өөрт шаардлагатай мэдээллийг МэҮЭ-ийн бусад нэгжээс авч чадаж буй эсэх, цалин, урамшууллын байдал/

4.2.5 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлын талаар МэҮЭ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд /удирдлагад/ тайлагнаж буй эсэх, тайлангийн хувийг СМА-д ирүүлж буй эсэх;

4.2.6 Ажилтны ажлыг хянах, үнэлэлт дүгнэлт өгөх, хариуцлага тооцох тогтолцоо тодорхой эсэх;

4.2.7 СМА-ны болон бусад дотоод гадаадын байгууллагаас зохион байгуулсан сургалт, семинарт хамрагдсан эсэх;

4.2.8 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр тухайн МэҮЭ-ийн ажилтнуудад зориулсан сургалт явуулж буй эсэх. /Тухайн жилийн эсвэл улирлын сургалтын хуваарь, сэдэв, материал, сургалтыг зохион байгуулсан газар, огноо. Сургалтад хамрагдсан ажилтнуудын бүртгэл, Сургалтад хамрагдсан ажилтан нарын сургалтын талаарх сэтгэгдэл, үнэлгээ болон хийгдсэн санал асуулга/

II. Харилцагчийг таньж, мэдэх талаар МэҮЭ-ийн үйл ажиллагаа:

4.2.9 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой хууль бус үйлдэлд өртөхөөс сэргийлэх зорилгоор “Харилцагчийг таньж мэдэх” талаар өөрийн дотоод хяналтын хөтөлбөртөө заалт оруулан мөрдөж буй эсэх;

4.2.10 “Харилцагчийг таньж мэдэх” талаар дээрх заалтыг зөрчсөн ажилтантай тооцох хариуцлага тодорхой эсэх;

4.2.11 Харилцагчийн эрсдлийн түвшинг тогтоож, өндөр эрсдэл бүхий харилцагчийн дансыг тусгайлан хянаж, тогтсон хэм хэмжээнээс гадуурх гүйлгээг нь нягтлан шалгаж буй эсэх;

4.2.12 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалт болон Хорооны даргын 2009 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 253 дугаар тогтоолоор батлагдсан “Харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам”-ын 2.1-д заасан мэдээллийг данс нээх, гүйлгээ хийх, санхүүгийн бусад үйлчилгээ үзүүлэхийн өмнө харилцагчаас бүрэн гаргуулан авч буй эсэх;

4.2.13 Шаардлагатай мэдээллийг гаргаж өгөхөөс татгалзсан этгээдэд данс нээх, гүйлгээ хийх, санхүүгийн бусад үйлчилгээ үзүүлэхээс татгалзаж буй эсэх;

4.2.14 Харилцагчийн МэҮЭ-д өгсөн мэдээлэл нь буруу, ташаа болох нь

тогтоогдсон бөгөөд харилцагч энэ талаар тайлбар өгөхөөс татгалзсан, хуурамч мэдээлэл өгсөн бол харилцагчийн хийсэн гүйлгээний талаар сэжигтэй гүйлгээний тайланг СМА-нд илгээж, харилцагчтай байгуулсан гэрээгээ цуцалж буй эсэх;

4.2.15 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэхь заалтыг хэрэгжүүлж буй эсэх;

4.2.16 Харилцагчийн тухай мэдээлэлд орсон нэмэлт, өөрчлөлт бүрийг бүртгэж, мэдээллийн багцыг 2 жил тутам шинэчилж буй эсэх;

4.2.17 Нэргүй, дугаарласан, эсхүл хуурамч нэрээр данс нээсэн түүнийг ашиглан гүйлгээ хийсэн, хаагдсан данс ашигласан явдал байгаа эсэх;

4.2.18 Гадаад улсад бүртгэгдсэн гэх боловч биетээр оршдоггүй, тухайн орны санхүүгийн зохицуулалтад үл хамаарах банк, санхүүгийн байгууллага эсвэл эдгээртэй харилцдаг хуулийн этгээдтэй харилцаа тогтоосон эсэх;

4.2.19 Гадаадын банк, санхүүгийн байгууллагатай харилцаа тогтоохын өмнө тухайн банк, санхүүгийн байгууллагын талаархи мэдээллийг холбогдох журмын дагуу судалж байгаа эсэх;

4.2.20 Харилцагчийг таньж мэдэх шаардлагыг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж болох /интернет, телефон гэх мэт/ зайнаас хийгдэх гүйлгээгээр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдлээс сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлж буй эсэх;

III. Сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэхтэй холбоотой үйл ажиллагаа:

4.2.21 Сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээний тайланг мэдээлэх талаар МэҮЭ-ийн дотоод хяналтын хөтөлбөрт заалт орсон эсэх;

4.2.22 Сэжигтэй болон бэлэн мөнгөн гүйлгээний тайланг мэдээлэх МэҮЭ-ийн дотоод журмыг зөрчсөн ажилтантай тооцох хариуцлага тодорхой эсэх;

4.2.23 Бэлэн мөнгөний гүйлгээний тайланг ажлын 7 өдрийн дотор СМА-нд батлагдсан загвар, зааврын дагуу хүргүүлж буй эсэх;

4.2.24 Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайланг батлагдсан маягтын дагуу, хугацаанд нь СМА-нд хүргүүлж буй эсэх;

4.2.25 Тухайн нэг гүйлгээг сэжигтэй гүйлгээ гэж үзэх үндэслэлийн талаарх мэдээллийг холбогдох ажилтан бүрт өгсөн эсэх;

4.2.26 Сэжиглэх тодорхой үндэслэлгүй боловч, эргэлзээ төрүүлсэн гүйлгээний талаар хэрэгжилтэд хяналт тавих ажилтанд нэн даруй мэдэгдэх тогтолцоо бүрдсэн эсэх;

4.2.27 Сэжигтэй гүйлгээний тайланг зохих журмын дагуу бөглөн 24 цагийн дотор СМА-нд ирүүлж буй эсэх;

4.2.28 Гүйлгээг түдгэлзүүлэх эсхүл түдгэлзүүлсэн шийдвэрийг цуцлах тухай СМА-ны шийдвэрийг хүлээн авмагц нэн даруй хэрэгжүүлэх бололцоо бүрдсэн эсэх;

4.2.29 МэҮЭ-ийн дотоод журамд СМА-нд өгсөн гүйлгээний тайлан, эрх бүхий байгууллагад шилжүүлсэн мэдээллийн талаар харилцагчид өөрт нь болон гуравдагч хувь хүн, хуулийн этгээдэд мэдээлэл өгөхийг хориглосон зохицуулалт байгаа эсэх.

IV.Бичиг баримтын хадгалалт, тусгайлан хянах гүйлгээ болон МУТС-ээс урьдчилан сэргийлэх бусад үйл ажиллагаа:

4.2.30 МэҮЭ нь харилцагчийн гүйлгээ болон гадаад төлбөр тооцооны баримт бичгийг 5-аас доошгүй жилийн хугацаанд хадгалж буй эсэх;

4.2.31 МэҮЭ нь харилцагчийн нэр, хаягийг тогтоосон баримт, тухайлбал, иргэний үнэмлэх түүнтэй адилтгах бичиг баримт, жолооны үнэмлэхийн хуулбар, данс бүртгэлийн болон бичиг хэргийн харилцааны талаарх мэдээллийг холбогдох данс хаагдсанаас хойш 5-аас доошгүй жилийн хугацаанд хадгалж буй эсэх;

4.2.32 МэҮЭ-ийн харилцагчийн мэдээллийн бүртгэлээс гүйлгээний талаарх мэдээллийг, тухайлбал гүйлгээний дүн, гүйлгээний утга, хүлээн авагчийн талаар мэдээлэл авах бололцоотой байгаа эсэх;

4.2.33 Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан “НҮБ-ын тогтоолоор террорист гэж зарлагдсан байгууллага, этгээдийн нэрсийн жагсаалтыг гаргах, мэдээлэх, тэдгээрийн гүйлгээг түдгэлзүүлэх тухай журам”-ыг үйл ажиллагаандаа ашиглаж буй эсэх;

4.2.34 “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”-ийн 6 дугаар зүйлд заасан тусгайлан хянах гүйлгээтэй холбогдолтой нэмэлт арга хэмжээ авч байгаа эсэх;

4.2.35 Хяналт шалгалтад санаатайгаар саад учруулж буй эсэх;

4.2.36 Тухайн МэҮЭ-д өмнө нь хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар хийгдсэн ажил.

4.3 Тодорхой мэдээллийн дагуу хийгдэх гэнэтийн шалгалтын явцад зөвхөн тухайн мэдээлэлтэй холбоотой гэж үзэх бүх үндсэн баримт материалд шалгалт хийнэ.

ТАВ. НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ ӨГӨХ

5.1 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр МэҮЭ-ийн үйл ажиллагаанд нэгдсэн үнэлгээ, дүгнэлт өгөхдөө дараахь зарчмыг шалгалтын ажлын хэсэг баримтална:

5.1.1 Шалгалтын ажлын хэсгийн гишүүд нь өөрсдийн хариуцаж хяналт

шалгалт хийсэн чиглэлээр энэ журмын 1,2,3,4 дүгээр хавсралтын дагуу үнэлгээ өгнө.

5.1.2 Шалгалтын ажлын хэсгийн ахлагч нь хэсэг тус бүрт өгсөн үнэлгээг харгалзан нэгдсэн үнэлгээ өгнө. Шалгалтын хэсгийн бүх гишүүд гарын үсэг зурж, шалгалтын хэсгийн ахлагч улсын байцаагчийн тэмдэг дарж нэгдсэн үнэлгээг баталгаажуулна.

5.1.3 Нэгдсэн үнэлгээг харгалзан МэҮЭ-ийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг дараах байдлаар дүгнэж болно:

- a) 1 буюу хууль тогтоомжийг хэрэгжүүлж байна;
- b) 2 буюу хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай;
- c) 3 буюу хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй.

5.2 Тодорхой мэдээллийн дагуу хийгдсэн гэнэтийн шалгалтын дараа нэгдсэн үнэлгээ хийгдэхгүй. Зөвхөн мэдээлэлтэй холбоотой улсын байцаагчийн дүгнэлт гарч түүний дагуу шаардлагатай арга хэмжээг авна.

ЗУРГАА. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ДҮГНЭЛТ БЭЛТГЭХ, ТАНИЛЦУУЛАХ

6.1 Хяналт шалгалт дууссанаас хойш ажлын таван өдөрт багтааж хяналт шалгалтын дүгнэлтийг СМА-ны даргад танилцуулна.

6.2 Хяналт шалгалтын дүгнэлт нь дараахь мэдээллийг агуулсан байна:

6.2.1 Тухайн МэҮЭ-д хийгдсэн хяналт шалгалтын чиглэл, арга, хамрагдсан хүрээ, хяналт шалгалтыг хийсэн огноо.

6.2.2 Зөрчил гаргасан этгээдийн нэр, албан тушаал, зөрчигдсөн хууль тогтоомжийн нэр, зүйл, хэсэг, заалтыг тодорхой заасан улсын байцаагчийн акт.

6.2.3 Улсын байцаагчийн актад хууль тогтоомж зөрчигдсөнийг нотлох баримтыг хавсаргасан байна.

6.2.4 Тухайн МэҮЭ-ийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэгдсэн дотоод журмынх нь хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт хийсэн байна.

6.2.5 Шалгалтын явцад газар дээр нь шууд засч залруулж болох зөрчил дутагдал илэрснийг засч залруулах талаар шуурхай арга хэмжээ авсан бол тэмдэглэл хийсэн байна.

6.2.6 Шалгалтын явцад санал гомдол хүлээн авсан бол түүнийг хэрхэн шийдвэрлэсэн талаар тайлбар хийсэн байж болно.

6.2.7 Өмнөх шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар өгсөн

үүрэг, даалгаврын биелэлтийн талаар нотлох баримттай дүгнэлт өгсөн байна.

6.3 Шалгалтын дүнг МэҮЭ хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд шалгалтын дүгнэлт эсхүл мэдэгдэлтэй танилцсанаас хойш ажлын 10 хоногийн дотор СМА-ны даргад бичгээр гомдол гаргаж болно.

6.4 Шалгалтын дүгнэлтийг тухайн МэҮЭ-ийн хавтаст хэрэгт хавсаргана.

ДОЛОО. ХАРИУЦЛАГА

7.1 Холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд Монголбанкны СМА-ны хянан шалгагч, “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хууль бусад хууль тогтоомжид заагдсан захиргааны шийтгэл болон албадлагын арга хэмжээг авна.

_____оОо_____

ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ АЖИЛТНЫ ЭРХ ҮҮРЭГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Д/Д	ХАРГАЛЗАХ ХҮЧИН ЗҮЙЛС	Тийм	Үгүй	Зөрчил, дутагдал
1.	Хэрэгжилтэд хяналт тавих ажилтны боловсрол, дадлага туршлага болон ёс суртахууны байдал нь эрхлэж буй ажилдаа тохирч байгаа эсэх.			
2.	Хэрэгжилтэд хяналт тавих ажилтан нь гүйлгээг сэжигтэй гүйлгээ гэж тооцон холбогдох тайланг илгээх шийдвэрийг бие даан гаргах эрхтэй эсэх, энэ шийдвэрт МэҮЭ-ийн удирдлагын оролцоо байгаа эсэх.			
3.	Хэрэгжилтэд хяналт тавих ажилтан нь ажил үүргээ хариуцлагатай гүйцэтгэх нөхцөл бололцоогоор хангагдсан эсэх. /Ажлын байр, холбоо, харилцааны хэрэгсэл, компьютер, программ хангамж, өөрт шаардлагатай мэдээллийг МэҮЭ-ийн бусад нэгжээс авч чадаж буй эсэх, цалин, урамшуулалын байдал/			
4.	Хэрэгжилтэд хяналт тавих ажилтны ажлыг хянах, үнэлэлт дүгнэлт өгөх, хариуцлага тооцох арга механизм тодорхой эсэх.			
5.	Хэрэгжилтэд хяналт тавих ажилтан нь СМА-ны болон бусад дотоод гадаадын байгууллагаас зохион байгуулсан сургалт, семинарт хамрагдсан байдал.			
6.	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр тухайн МэҮЭ-ийн ажиллагсадад зориулсан сургалт явуулж буй эсэх. /Сургалтын хуваарь, сэдэв, материал, сургалтыг зохион байгуулсан газар, огноо, Сургалтанд хамрагдсан ажилтнуудын бүртгэл, Сургалтанд хамрагдсан ажилтан нарын сургалтын талаарх сэтгэгдэл, үнэлгээ болон хийгдсэн санал асуулга/			
7.	Хэрэгжилтэд хяналт тавих ажилтан нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлын талаар МэҮЭ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд /удирдлагад/ тайлагнаж буй эсэх, тайлангийн хувийг СМА-д ирүүлж буй эсэх			

ОГНОО:

ҮНЭЛГЭЭ:

ХЯНАН ШАЛГАГЧИЙН НЭР:

ГАРЫН ҮСЭГ:

ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ ТАЛААР МЭҮЭ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Д/Д	ХАРГАЛЗАХ ХҮЧИН ЗҮЙЛС	Тийм	Үгүй	Дутагдал	Зөрчигдсөн зүйл, заалт
1.	Харилцагчийг таньж мэдэх талаар дотоод журамтай эсэх.				
2.	“Харилцагчийг таньж мэдэх” талаар МэҮЭ-ийн дотоод журмыг зөрчсөн ажилтантай тооцох хариуцлага тодорхой эсэх.				
3.	Харилцагчийн эрсдлийн төвшинг тогтоож, өндөр эрсдэл бүхий харилцагчийн дансыг тусгайлан хянаж, тогтсон хэм хэмжээнээс гадуурх гүйлгээг нь нягтлан шалгаж буй эсэх.				
4.	“Харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам”-ын 2.1-д заасан мэдээллийг данс нээх, гүйлгээ хийх, санхүүгийн бусад үйлчилгээ үзүүлэхийн өмнө харилцагчаас бүрэн гаргуулан авч буй эсэх.				
5.	Шаардлагатай мэдээллийг гаргаж өгөхөөс татгалзсан этгээдэд данс нээх, гүйлгээ хийх, санхүүгийн бусад үйлчилгээ үзүүлэхээс татгалзаж буй эсэх.				
6.	Харилцагчийн МэҮЭ-д өгсөн мэдээлэл нь буруу, ташаа болох нь тогтоогдсон бөгөөд харилцагч энэ талаар тайлбар өгөхөөс татгалзсан, хуурамч мэдээлэл өгсөн бол харилцагчийн хийсэн гүйлгээний талаар сэжигтэй гүйлгээний тайланг СМА-нд илгээж, харилцагчтай байгуулсан гэрээгээ цуцалж буй эсэх.				
7.	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэхь заалтыг хэрэгжүүлж буй эсэх.				
8.	Харилцагчийн тухай мэдээлэлд орсон нэмэлт, өөрчлөлт бүрийг бүртгэж, мэдээллийн багцыг 2 жил тутам шинэчилж буй эсэх.				
9.	Нэргүй, дугаарласан, эсхүл хуурамч нэрээр данс нээсэн түүнийг ашиглан гүйлгээ хийсэн, хаагдсан данс ашигласан явдал байгаа эсэх.				
10.	Гадаад улсад бүртгэгдсэн гэх боловч биетээр оршдоггүй, тухайн				

	орны санхүүгийн зохицуулалтад үл хамаарах банк, санхүүгийн байгууллага эсвэл эдгээртэй харилцдаг хуулийн этгээдтэй харилцаа тогтоосон эсэх.				
11.	Гадаадын банк санхүүгийн байгууллагатай харилцаа тогтоохын өмнө тухайн байгууллагын талаархи мэдээллийг холбогдох журмын дагуу судалж байгаа эсэх.				
12.	Харилцагчийг таньж мэдэх шаардлагыг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж болох /интернет, телефон гэх мэт/ зайнаас хийгдэх гүйлгээгээр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдлээс сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлж буй эсэх.				
13.	Тухайн МэҮЭ-д өмнө нь хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн энэ хэсэгт хамаарах зөрчил дутагдлыг арилгах талаар ажил хийгдсэн эсэх.				

ОГНОО:

ҮНЭЛГЭЭ:

ХЯНАН ШАЛГАГЧИЙН НЭР:

ГАРЫН ҮСЭГ:

СЭЖИГТЭЙ БОЛОН БЭЛЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭГ МЭДЭЭЛЭХТЭЙ
ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Д/Д	ХАРГАЛЗАХ ХҮЧИН ЗҮЙЛС	Тийм	Үгүй	Дутагдал	Зөрчигдсөн зүйл, заалт
1.	Сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээний тайланг бэлтгэх, мэдээлэх талаар дотоод журамтай эсэх.				
2.	Сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээний тайланг мэдээлэх дотоод журмыг зөрчсөн ажилтантай тооцох хариуцлага тодорхой эсэх.				
3.	Бэлэн мөнгөний гүйлгээний тайланг ажлын 7 өдрийн дотор СМА-нд батлагдсан загвар, зааврын дагуу хүргүүлж буй эсэх.				
4.	Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайланг батлагдсан маягтын дагуу, хугацаанд нь СМА-нд хүргүүлж буй эсэх.				
5.	Тухайн нэг гүйлгээг сэжигтэй гүйлгээ гэж үзэх үндэслэлийн талаарх мэдээллийг холбогдох ажилтан бүрт өгсөн эсэх.				
6.	Сэжиглэх тодорхой үндэслэлгүй боловч, эргэлзээ төрүүлсэн гүйлгээний талаар хэрэгжилтэд хяналт тавих ажилтанд нэн даруй мэдэгдэх тогтолцоо бүрдсэн эсэх.				
7.	Сэжигтэй гүйлгээний тайланг зохих журмын дагуу бөглөн 24 цагийн дотор ирүүлж буй эсэх.				
8.	Гүйлгээг түдгэлзүүлэх эсхүл түдгэлзүүлсэн шийдвэрийг цуцлах тухай СМА-ны шийдвэрийг хүлээн авмагц нэн даруй хэрэгжүүлэх бололцоо бүрдсэн эсэх.				
9.	МэҮЭ-ийн дотоод журамд СМА-нд өгсөн гүйлгээний тайлан, эрх бүхий байгууллагад шилжүүлсэн мэдээллийн талаар харилцагчид өөрт нь болон гуравдагч хувь хүн, хуулийн этгээдэд мэдээлэл өгөхийг хориглосон зохицуулалт байгаа эсэх.				

10.	Тухайн МэҮЭ-д өмнө нь хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн энэ хэсэгт хамаарах зөрчил дутагдлыг арилгах талаар ажил хийгдсэн эсэх.				
-----	--	--	--	--	--

ОГНОО:

ҮНЭЛГЭЭ:

ХЯНАН ШАЛГАГЧИЙН НЭР:

ГАРЫН ҮСЭГ:

БИЧИГ БАРИМТЫН ХАДГАЛАЛТ, ТУСГАЙЛАН ХЯНАХ ГҮЙЛГЭЭ БОЛОН
МУТС-ЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Д/Д	ХАРГАЛЗАХ ХҮЧИН ЗҮЙЛС	Тийм	Үгүй	Зөрчил, дутагдал
1.	Хянан шалгалтанд санаатайгаар саад учруулж буй эсэх.			
2.	МэҮЭ нь харилцагчийн нэр, хаягийг тогтоосон баримт, тухайлбал иргэний үнэмлэх түүнтэй адилтгах бичиг баримт, жолооны үнэмлэхийн хуулбар, данс бүртгэлийн болон бичиг хэргийн харилцааны талаарх мэдээллийг холбогдох данс хаагдсанаас хойш 5-аас доошгүй жилийн хугацаанд хадгалж буй эсэх.			
3.	МэҮЭ-ийн харилцагчийн мэдээллийн бүртгэлээс гүйлгээний талаарх мэдээллийг, тухайлбал гүйлгээний дүн, гүйлгээний утга, хүлээн авагчийн талаар мэдээлэл авах бололцоотой байгаа эсэх.			
4.	Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан “НҮБ-ын тогтоолоор террорист гэж зарлагдсан байгууллага, этгээдийн нэрсийн жагсаалтыг гаргах, мэдээлэх, тэдгээрийн гүйлгээг түдгэлзүүлэх тухай журам”-ыг үйл ажиллагаандаа ашиглаж буй эсэх.			
5.	“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”-ийн 6 дугаар зүйлд заасан тусгайлан хянах гүйлгээнүүдтэй холбогдолтой нэмэлт арга хэмжээ авч байгаа эсэх,			
6.	Тухайн МэҮЭ-д өмнө нь хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн энэ хэсэгт хамаарах зөрчил дутагдлыг арилгах талаар ажил хийгдсэн эсэх.			

ОГНОО:

ҮНЭЛГЭЭ:

ХЯНАН ШАЛГАГЧИЙН НЭР:

ГАРЫН ҮСЭГ: